



**ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙН ТУХАЙ
НҮБ-ЫН АСУУЛГА СУДАЛГАА**



**ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААР
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХАРИУЛТ**

АГУУЛГА ;

- **Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх эрхзүйн орчны байдал**
- **Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцдэг байгууллагын бүтэц тогтолцоо, уялдаа холбоо**
- **Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд хандах нийгмийн хандлага**
- **Хүчирхийллийн эсрэг хүүхдүүдийн үйл ажиллагаа**
- **Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх бодлого, хөтөлбөр**
- **Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдээлэл судалгаа, дүн шинжилгээ**
- **Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар олон түмний мэдлэг, сурталчилгаа, сургалт**

2005 оны 01 сарын 15

УЛААНБААТАР ХОТ

“ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛ” АСУУЛГА СУДАЛГААНЫ ХАРИУЛТ

- 1. Асуулт -1 Хүүхдийн эрхийн тухай Конвенц, түүний нэмэлт протоколууд, Палермогийн Протокол болон бүс нутгийн хүний эрхийн талаарх баримт бичгүүд зэрэг олон улсын хүний эрхийн баримт бичгүүдийг хүлээн зөвшөөрснөөр хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд дэвшил гарсан уу. Танай орны Шүүх хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар шийдвэр гаргахдаа олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн баримт бичигт дурьдсан хэм хэмжээг авч хэрэглэсэн тохиолдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү.*

Монгол Улс Хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой Олон улсын 30 гаруй конвенцид нэгдэн орсон юм. Тухайлбал Хүний эрхийн тухай түгээмэл тунхаглалд 1959 онд, Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцид 1990 онд, түүний нэмэлт протоколуудад 2002 онд, ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглох, нэн даруй устгах тухай Конвенцид 2002 онд тус тус нэгдэн орсон. Монгол Улс Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тухай НҮБ-ын Конвенци, түүний нэмэлт протоколуудад нэгдэн орох асуудлыг судалж, бэлтгэл ажлыг хийж байна.

Манай улс Үндсэн хуулийнхаа үзэл баримтлал болон олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх ажлын хүрээнд хүний эрх, хүүхдийн эрх, эрх чөлөөг хангах, түүнийг зөрчигдөхөөс хамгаалах асуудлыг үндэснийхээ хуульд тусган хэрэгжүүлэх ажлыг тодорхой үе шаттай хийж байна. Одоогоор тус улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа 300 гаруй хуульд хүүхдийн эрхийн холбогдолтой нийт 350 орчим заалт тусгагдсан байна.

Монгол Улс Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль /1996/, Гэр бүлийн тухай хууль /1999/, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай /1997/, Хараа хяналтгүй хүүхдийг албадан саатуулах тухай хууль /1997/ зэрэг бие даасан хуулиудад хүүхдийг хүчирхийллээс ангид байлгах, хамгаалах асуудлыг тусган хэрэгжүүлж байна.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай Монгол улсын хуулиар Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын Конвенцид заагдсан үндсэн эрхийг баталгаажуулсан бөгөөд 2003 онд энэ хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр хүүхдийг худалдах, дамлан худалдах, боолчлох буюу түүнтэй адилтгах нөхцөлд байлгах, хүчирхийлэлд өртөх, хяналтгүй орхиоос хамгаалах заалт шинээр орсон.

Энэ нь хүүхдийн эрх, эрх чөлөөг хамгаалах, түүнийг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд Монгол Улс тодорхой амжилт олж байгааг харуулж байна.

Түүнчлэн үндэсний хуулиас гадна Олон улсын гэрээ, Конвенци болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсад хүний эрхийг хангах хөтөлбөр/2003/, Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөр/2002/, Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр /1999/-ийг батлан хэрэгжүүлж байна.

Төрөөс хүчирхийлэлтэй тэмцэхэд томоохон алхам хийж “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” бие даасан шинэ хуулийг 2004 онд баталлаа.

Энэ хуульд зааснаар гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүмүүсийн аль нэг нь нөгөөгийнхөө эрх, эрх чөлөөг зөрчиж гэм хор учруулсан, эсхүл учруулахаар заналхийлсэн бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдэхүйг гэр бүлийн хүчирхийлэл гэж үзэн, энэхүү хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэхтэй холбогдон үүсэх харилцааг бүхэлд нь зохицуулахаар тусгасан байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн шинжтэй хэргүүдийг Хүүхдийн эрхийн талаарх олон улсын гэрээ конвенцийн тодорхой заалтыг үндэслэн шийдвэрлэсэн жишээ одоогоор бүртгэгдээгүй байна. Гэхдээ Монгол Улсын шүүх аливаа хэргийг шийдвэрлэхээр хуулийг хэрэглэхдээ Үндсэн хуулиар тодорхойлсон “Монгол Улс эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтлах бөгөөд олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсноор дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэх зарчим”-ыг удирдлага болгож байгаа юм. Хууль санаачлагч, тогтоогчид нь аливаа хуулийг боловсруулах, батлан гаргахдаа Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцүүлэх зарчмыг ямагт баримталдаг.

2. Асуулт-2 Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, эрх зүйн энгийн баримт бичгүүдэд хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрийг хэрхэн тодорхойлсон бэ?

- Монгол Улсын Үндсэн хуульд хүнийг нас хүйс, үндэс угсаа, нийгмийн гарлыг үл харгалзан улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцох, гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаалахыг заасан нь хүүхдийг хүчирхийллээс хамгаалах язгуур эрхийг олгосон юм.
- Монгол Улсын Эрүүгийн хуульд (2002 онд) “Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг” гэсэн бие даасан бүлэг нэмж оруулсан бөгөөд дараахь хэлбэрийн үйлдлийг гэмт хэрэгт тооцон шийтгэл хүлээлгэх заалт тусгасан. Үүнд;
 - хүүхдийг солих
 - хууль бусаар үрчлэх
 - хаях, төөрүүлэх
 - асран хамгаалах үүргээ урвуулах
 - сургуулийн өмнөх насны хүүхдийг халамжлах үүрэгт ажилдаа хайнга хандах
 - эцэг, эх, эхнэр, нөхөр төрүүлсэн буюу үрчилж авсан хүүхдээ тэжээн тэтгэхээс ноцтой зайлсхийх
 - хүүхдийг албадан хөдөлмөрлүүлэх зэрэг нь хүүхдийн эсрэг хүчирхийллийн шинжтэй үйлдэл болохыг тодорхойлсон.
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрийг дараах, байдлаар тодорхойлсон. Үүнд;

- хүүхдийг доромжлох, басамжлах, гүтгэх
- хүчирхийлэх, хулгайлах, барьцаанд өгөх
- худалдах, санаатай солих, хаях, төөрүүлэх
- тарчлаан зовоох, тагнуул, хорлон сүйтгэх ажиллагаанд ашиглах
- бага насанд нь сүй тавьж, албадан гэрлүүлэх, хууль бусаар үрчлүүлэх
- хорьж цагдах, хууль бусаар гадаадад авч гарах, гадаадаас оруулж ирэх
- хүүхдийг дамжуулан худалдах, боолчлох буюу түүнтэй адилтгах нөхцөлд байлгах зэргийг хориглож, улмаар хүүхдийг хүчирхийлэлд өртөх, хараа хяналтгүй орхихоос сэргийлэх үүрэгтэйг хуульчилсан.

3. Асуулт-3 Хууль тогтоомжид дараахь асуудлаар тодорхой заалтууд байгаа эсэх;

- Хүүхдийн эсрэг бие махбодь, сэтгэл санаа, бэлгийн хүчирхийлэл, гэмтэл, дарамт шахалт зэрэг бүх хэлбэрийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх
- Хүүхдийг хүчирхийллийн бүх хэлбэрээс хамгаалах
- Хохирогч хүүхдэд нөхөн төлбөр олгох
- Гэм буруутанг шийтгэх
- Хохирогч хүүхдийг нөхөн сэргээх, хэвийн амьдралд нь буцаан оруулах

Урьдчилан сэргийлэх талаар

“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуульд гэр бүлийн хүчирхийлэл нь бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн, эдийн засгийн, айлган сүрдүүлэх, мөрдөн мөшгөх, бусдаас тусгаарлах зэрэг нийтлэг хэлбэрээр илэрч болохыг тодорхойлсон. Энэ хуульд хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд Засгийн газар, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудын хүлээх үүрэг, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон. “Гэр бүлийн тухай” хуульд гэрлэгчийн хэн нэгний амь нас, эрүүл мэнд, хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учирч, эсвэл учирсан нь тогтоогдсон бол эвлэрүүлэх арга хэмжээ авалгүйгээр гэрлэлтийг цуцлахаар заасан нь хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлсэн нэг арга хэрэгсэл болсон.

Хамгаалах, нөхөн сэргээх талаар

Монгол улсын төрөөс Хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, Гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлогод хүүхдийг хүчирхийллээс хамгаалах, хохирогчдод нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүмүүсийг түр хамгаалах байраар хангах зэрэг тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан байна.

Хүүхдийг аливаа гэмт хэрэг, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн болон түүнд холбогдсон насанд хүрээгүй хүний эрхийг хамгаалах зэрэг үйл ажиллагааг Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр, Хүүхэд, түүний эсрэг

гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр зэрэг баримт бичгүүдэд тусган хэрэгжүүлж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хохирогчид нийгмийн үйлчилгээ үзүүлэх, эрх зүйн болон бусад мэдээлэл, зөвлөгөө өгөх, эмчилгээ хийх, нөхөн сэргээх асуудлыг зохион байгуулахаар тусгасан байна.

Хариуцлага шийтгэл

Монгол Улсын Эрүүгийн хуульд хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлагуудыг /торгох, баривчлах, хорих/ хүлээлгэхээр, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хүчирхийлэгчийг тусдаа амьдрахыг даалгах, асрамжиндаа байгаа насанд хүрээгүй хүнтэй харилцахыг хориглох, согтуурах, мансуурах донтой этгээдийг хуулийн дагуу албадан эмчлэх зэрэг хариуцлагыг тогтоосон байна. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 25 дугаар зүйлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр дараах шийтгэлийг оногдуулна. Үүнд ;

- Хүүхдийг сэтгэл санаа, биемахбодийн дарамтад байлгасан, хавчиж, шахаж хүч хэрэглэсэн иргэн, албан тушаалтанг 40-50 мянган төгрөгөөр торгох буюу 30 хоног хүртэл хугацаагаар баривчлах
- Хүүхдийг хувцас, хоол хүнс, орон байраар санаатай гачигдуулсан, хүүхдэд эрүүл ахуйн шаардлагад нийцээгүй хоол хүнсний зүйлийг санаатай хэрэглүүлсэн иргэн, албан тушаалтанг 35-50 мянган төгрөгөөр торгох
- Хүүхдээр гүйлгэ гүйлгэсэн иргэн, эрүүл мэндэд харшлах ажил хөдөлмөр хийлгэсэн албан тушаалтанг 10-20 мянган төгрөгөөр торгох
- Төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдээ хаясан, төөрүүлж орхисон иргэнийг 50 мянга хүртэл төгрөгөөр торгох буюу 30 хүртэл хоногоор баривчлахаар заасан байна.

4. Асуулт-4 Гэр бүл, сургууль, цэцэрлэг, нийгмийн үйлчилгээний газар, цэргийн сургууль, хорих газар, ажлын байр, спортын байгууламж, нийгэм хамт олны орчинд хүүхдийн эсрэг биемахбод, сэтгэл санаа, бэлгийн хүчирхийлэл, дарамт , үл хайхрах зэрэг хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, эрхзүйн тусгай заалт байгаа эсэх

Монгол Улсын Иргэний хууль, Эрүүгийн хууль болон Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Хөдөлмөрийн тухай, Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай зэрэг хуульд хүүхдийн эсрэг хүчирхийлэл гардаг орчныг тодорхойлон заасан. Тухайлбал;

- Гэр бүлийн тухай хуульд эцэг, эх нь хүүхдийн эрүүл мэнд, сэтгэхүй, ёс суртахууны хүмүүжилд хохирол учруулах, хүүхэддээ хэрцгий хандах, эцэг, эх байх эрхээ зүй бусаар ашиглахыг хориглосон;

- Эрүүгийн хуульд төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдээ хаясан, төөрүүлсэн бол албадан ажил хийлгэх, баривчлах, үүний улмаас хүүхдийн амь нас хохирсон, хүнд хор уршиг учирсан бол хорих хүртэл ял шийтгэл оногдуулах, сургуулийн өмнөх насны хүүхдийг халамжлах үүрэг бүхий этгээд үүрэгт ажилдаа хайнга хандсаны улмаас хүүхдэд хор уршиг учирвал торгох, баривчлах, түүнчлэн хорих ялаар шийтгэх, хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлсэн бол мөн адил торгох эсхүл хорих ял оногдуулах зүйл, заалтыг тусган хэрэгжүүлж байна.
- Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд хоригдож байгаа насанд хүрээгүй этгээдийг ахуй нөхцөлийн хувьд сайжруулсан байранд байлгаж, түүнд өгөх хоолны илчлэгийн хэмжээг нэмэгдүүлэх, тэднийг бусад сэжигтэн, яллагдагчаас тусгаарлан хорих тухай заалт бий.

Асуулт 5. Хүүхдийг бие махбодийн хувьд шийтгэдэг явдлыг хориглох талаар хуулийн тодорхой зүйл заалт бий эсэх (Үүнд гэр бүлийн хүрээ орно). Хүүхдэд бие махбодийн шийтгэл үзүүлсэн хүнд хариуцлага хүлээлгэх тухай дэлгэрэнгүй бичнэ үү

- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд хүүхдийг сэтгэл санааны болон бие махбодийн дарамтад байлгасан, хавчин шахаж хүч хэрэглэсэн иргэн, албан тушаалтныг торгох буюу баривчлах шийтгэл ногдуулахаар заасан.
- Эрүүгийн хуульд бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулсан буюу хараа, сонсголгүй болгосон, эрхтнээс нь хагацуулсан, ажиллагаагүй болгосон, нүүрийг засаршгүй эвдэж дүрсийг алдагдуулсан, хүүхэд дутуу гаргуулсан, сэтгэцийн өвчтэй болгосон, түүнчлэн хөдөлмөрийн чадварыг бүрмөсөн алдагдуулсан бол хорих ял шийтгэхээр заасан.

Асуулт 6. Арван найм хүртэл насны хүнд цаазаар авах ял оноодог эсэх

Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээдэд цаазаар авах ял оногдуулахгүй гэж Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан. Монгол Улсын эрүүгийн бодлогод уг ялыг оногдуулах хэргийн төрлийг цөөрүүлэх, ялын төрлөөс хасах чиглэлийг баримталж байна.

Асуулт 7. Давуу байдлаа ашиглан бэлгийн өнгөлзлөг хийх, хэл амаар доромжлох, хүчирхийлэх талаар хуульд тодорхой заалтууд байгаа эсэх

Эрүүгийн хууль болон Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Садар самуун явдалтай тэмцэх тухай зэрэг хууль болон бусад эрхийн актад бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар тодорхой заалтууд бий. Тухайлбал;

Эрүүгийн хуульд насанд хүрээгүй хүнд бэлгийн замын халдварт өвчин халдаасан бол торгох, хорих ял шийтгэх, согтуурал, мансуурал, тэнүүчлэл, гуйланчлал болон биеэ үнэлэхэд татан

оролцуулсан бол албадан ажил хийлгэх, эсвэл баривчлах, насанд хүрсэн этгээд хохирогчийг арван зургаан насанд хүрээгүй гэдгийг мэдсээр байж хурьцал үйлдсэн бол торгох, албадан ажил хийлгэх, хорих; хохирогчид хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, эсхүл бусдын биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан хурьцал үйлдсэн бол хорих ял шийтгэхээр тус тус заасан.

Монгол Улсын төрөөс Хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт хүүхдийг садар самууны зорилгоор ашиглах, үл хайхрах, доромжлох, хэрцгийлэх, гэмт хэрэгт татан оруулах, дамжуулан худалдах зэрэг болзошгүй аюулаас хамгаалах, хүүхдийн эсрэг хүчирхийллийг хязгаарлах сургалт сурталчилгааг өргөжүүлж, энэ талаар иргэдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулахаар тусган хэрэгжүүлж байна.

Асуулт 8. Эмэгтэй хүний бэлэг эрхтнийг эрэмдэглэх, хүүхдийг гэрлүүлэх, нэр төрийг гутаах зэрэг хор нөлөөтэй зан заншил байдаг бол тэр талаар мэдээлэл бичнэ үү.

Ийм заншил байхгүй. Үндсэн хууль, Гэр бүлийн тухай хүүлийн дагуу 18 насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй иргэн сайн дурын үндсэн дээр гэрлэнэ.

Асуулт 9. Иргэний харьяалалгүй болон орогнол хүсэгч хүүхдийн эсрэг бүх төрлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай тусгайлсан заалт байгаа эсэх, хэрэв тусгайлсан заалт байхгүй бол тэднийг хэрхэн хамгаалдаг талаар мэдээлэх

Иргэний харьяалалгүй болон орогнол хүсэгч хүүхдийн эсрэг бүх төрлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай тусгайлсан заалт байхгүй боловч Монгол Улсын Үндсэн хуульд тус улсад хууль ёсоор амьдран суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна гэж заасны дагуу тэдний эрх хамгаалагдах бүрэн боломжтой юм. Тухайлбал, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхдэд нэгэн адил хамаарахаар заасны дагуу хүүхдийн эрх хамгаалагдана.

Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай НҮБ-ын Конвенцид нэгдэн орох асуудлыг судалж байна.

Асуулт 10. Хүчирхийллийн тухай тодорхойлолт, үйлчилдэг хууль тогтоомж нь хохирогч болон гэмт этгээдийн нас, хүйс, тэдгээрийн хоорондын харилцаа холбооноос /хүүхдээ алах, гэр бүл дэх бэлгийн хүчирхийлэл, доромжлол, цусан төрлийн хүчирхийлэл болон зодож шийтгэх/шалтгаалж ялгаатай байдаг уу.

Эрүүгийн хуульд гэмт хэргийн шинжтэй хүчирхийлэл үйлдэгч болон түүний хохирогчийн насны байдал, тэдгээрийн хоорондын холбоог харгалзан тогтоосноор хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх хариуцлагыг ялгавартай оногдуулж өгдөг.

Мөн хуулиар насанд хүрээгүй хүнийг биеэ үнэлэхэд татан оролцуулсан гэмт хэрэг үйлдэгчид нь уг насанд хүрээгүй хүнийг

хүмүүжүүлэх үүргийг хуулиар хүлээсэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч үйлдсэн бол хэргийг хүндрүүлэх нөхцөл байдал болгон үзэж торгох, баривчлах зэрэг ялыг сонгож оногдуулах, харин арван дөрвөн насанд хүрээгүй хүүхдийг хүчиндсэн бол гэмт хэргийн онц хүндрүүлэх нөхцөл болгон хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэхээр заасан байна.

Түүнчлэн эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны доод хязгаарыг гэмт хэрэг үйлдэх үедээ арван зургаан насанд хүрсэн этгээд байхаар заасан бөгөөд арван дөрвөөс арван зургаа хүртэл насны этгээд зарим хүнд, онц хүнд гэмт хэрэг, түүний дотор "хүчиндэх" гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байдаг.

Улсын Дээд Шүүх хохирогчийг байнгын шинжтэй, хэвшмэл маягтай гурав ба түүнээс дээш олон удаа зодсон үйлдлийг "Байнга зодох", хоол үнд өгөхгүй өлсгөж цангаах, хүйтэн байранд түгжих, хүлэх, чимхэх, хазах зэрэг хүний бие эрхтэнд халдаж, сэтгэл санааны хувьд зовоосон үйлдлийг "Тарчлаах шинжтэй бусад үйлдэл"-д хамааруулахаар тайлбарласан /Энэ тайлбар хуулийн нэгэн адил үйлчлэх хүчин чадалтай эрх зүйн акт юм/ бөгөөд эдгээрийг шүүхээс ял оногдуулахдаа хүндрүүлэх нөхцөл болгон авч үздэг.

Асуулт 11. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн эрх зүйн хүрээнд цогц үнэлгээ хийсэн эсэх

Энэ асуудлаар тусгайлан хийсэн судалгаа байхгүй бөгөөд Хүүхэд, эмэгтэйчүүдийн аж байдалд хийсэн үнэлгээ (НҮБХС, 2000), ОУХБ-ын 182 дугаар Конвенц, Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын Конвенцийн нэмэлт протоколууд, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх Конвенц ба түүний нэмэлт протоколуудад Монгол Улс нэгдэн орох бэлтгэл ажлын хүрээнд хуулийн харьцуулсан судалгаа хийхэд хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудал хамаарагдсан. Эдгээр үнэлгээ, судалгаанд үндэслэн Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт "Хүүхдэд ээлтэй эрхзүйн шинэтгэл" гэсэн тусгай бүлэг оруулан хэрэгжүүлж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд хүүхдийг орчноос нь тусгаарлах, бусадтай харилцахыг хязгаарлах, хүүхдийг дамжуулан худалдах, боолчлох болон түүнтэй адилтгах нөхцөлд байлгах, амь насанд нь аюул учруулах хөдөлмөр эрхлүүлэх, ашиг хонжоо олох зорилгоор эрүүл мэнд, ёс суртахуунд нь харшлах тоглоом, наадамд оролцуулахыг хориглон, хүүхэд хүчирхийллээс ангид байх эрхтэйг заасан.

Асуулт 12. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн үр нөлөөнд судалгаа шинжилгээ хийсэн эсэх;

Монгол улс хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийг Эрүүгийн хууль, Эрүүгийн байцан шийтгэх хууль, Захиргааны хариуцлагын тухай болон бусад хуулийн хүрээнд зохицуулж байсан. Хүчирхийллийн гэмт хэргийн дийлэнх нь гэр бүлийн хүрээнд гардгийг үндэслэн 2004 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх

тухай хуулийг баталж 2005 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжүүлж эхэлсэн. Уг хуулийг боловсруулах явцад төрийн ба төрийн бус байгууллагууд хуулийн үр нөлөөнд хэд хэдэн төрөлжсөн судалгаа хийсэн.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн шүүх

Асуулт 13. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг шийдвэрлэдэг Шүүхийн бүтцийн тухай бичих. Гэр бүлийн буюу насанд хүрээгүй хүмүүсийн шүүх энэ асуудлыг онцгойлон хариуцдаг эсэх

Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн тухай хуульд зааснаар Монгол Улсын шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэнэ. Улсын дээд шүүх хяналтын шатны, аймаг, нийслэлийн шүүх давж заалдах шатны, сум буюу сум дундын, дүүргийн шүүх анхан шатны журмаар хэрэг, маргааныг хянан шийдвэрлэдэг.

Гэр бүл болон насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг хянан шийдвэрлэх дагнасан шүүх байхгүй боловч тусгайлсан шүүх байгуулах асуудлыг судалж, мэргэшсэн шүүгчдийг сургаж эхлээд байна.

БЭЛГИЙН ХАРЬЦААНД ОРОХ НАСНЫ ДООД ХЯЗГААР

Асуулт 14 Бэлгийн харьцаанд орох насны доод хязгаар, энэ нь эрэгтэй, эмэгтэй хүүхдэд ялгаатай эсэх, мөн эсрэг болон ижил хүйстний бэлгийн харьцааны хувьд энэ насыг хуульд ялгаатай заасан эсэх

Эрүүгийн хуульд арван зургаан насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдсэн бол гэмт хэрэгт тооцдог. Эрэгтэй, эмэгтэй хүүхдийн талаар ялган тогтоосон болон ижил хүйстний талаар хууль тогтоомжид тусгайлсан заалт байхгүй байна.

Асуулт 15 Эрэгтэй, эмэгтэйчүүдийн гэрлэх насны доод хязгаарын тухай мэдээлэх

Монгол Улсын Үндсэн хууль, Гэр бүлийн тухай хуулийн дагуу 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн эрэгтэй, эмэгтэй сайн дурын үндсэн дээр гэрлэж болно.

Монгол Улс 1991 онд Сайн дурын үндсэн дээр гэрлэх тухай болон гэрлэх нас, гэрлэлтийг бүртгэх тухай НҮБ-ын Конвенцид нэгдсэн.

ХҮҮХДИЙН ЭСРЭГ БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ

Асуулт 16. Эцэг эх болон бусад хүн хүүхдийн биеийг үнэлэх, садар самуунд уруу татах, хил дамжуулан худалдах зэрэг хууль бус аргаар бэлгийн зорилгоор ашиглахаас урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн тухай мэдээлэл өгөх.

Хохирогч болсон хүүхдийг хэрэгтэнд тооцохгүйн тулд авдаг арга хэмжээний талаар мэдээлэх

Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын Конвенцийн Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, садар самуунд сурталчлахын эсрэг нэмэлт протоколуудад Монгол улс нэгдэн орсон.Одоогоор хүүхдийг худалдсан гэмт хэрэг илрээгүй боловч гарах нөхцөл бий болсон.Ажилгүйдэл, ядуурлын сөрөг үр дагавар нь олон арван хүүхэд гэр орноосоо дайжих, сургууль завсардах, гудамжны тэнэмэл амьдралд орох, мансууруулах бодис хэрэглэх, хүнд хөдөлмөр эрхлэх, өсвөр насны охид биеэ үнэлэх зэрэг сөрөг үзэгдэл гарахаар нөлөөлөх болсон.

Нийгмийн хамгаалал, Хөдөлмөрийн яамны хүсэлтээр 2002 онд ЕСРАТ олон улсын байгууллагаас хүүхдийг хил дамжуулан худалдах, бэлгийн замаар ашиглагдахаас хамгаалах асуудалд нөхцөл байдлын судалгаа хийж зөвлөмж гаргасан. Зөвлөмжийн дагуу Монгол улсын Засгийн газар төрийн болон төрийн бус, олон улсын төрийн бус байгууллагатай хамтран энэ асуудлаар үндэсний хөтөлбөр боловсруулж байна.Энэ ажлын хүрээнд 2004 онд Аялал жуулчлалд хүүхдийг бэлгийн замаар ашиглагдах, хил дамжуулан худалдагдахаас сэргийлэх Ёс зүйн хэмжээнд гарын үсэг зурж, нийслэлд ажилладаг аялал жуулчлалын компани, зочид буудлын ажилтнуудад зориулсан сургалтыг зохион байгуулж эхлээд байна.Мөн ЕСРАТ байгууллагын сүлжээнд албан ёсоор элсэж, ЕСРАТ-Монгол байгууллагыг байгуулан 40 гаруй байгууллага гишүүнээр элсээд байна.

ХҮҮХДИЙН ПОРНОГРАФИ БОЛОН СӨРӨГ /СЭТГЭХҮЙ БОЛОН БИЕ МАХБОДИД ДАРАМТ УЧРУУЛАХ/ МЭДЭЭЛЭЛ

Асуулт 17. Хүүхдийн порнографийг үйлдвэрлэх, эзэмших, тараахыг хориглосон хууль тогтоомж болон бусад арга хэмжээний талаар мэдээлэл өгөх. Ялангуяа интернэтээр тарааж байгаа , үйлдвэрлэж байгаа порнографи хянах хяналтын талаар мэдээлэл өгөх

Садар самуун явдалтай тэмцэх тухай хуульд садар самууныг сурталчлах, ном, зохиол, зураг, кино, дүрс, бичлэг бусад зүйлийг бэлтгэн тараах, борлуулахыг хориглосон ерөнхий заалт бий. Харин хүүхдийн порнографийг хязгаарласан, хориглосон нарийвчилсан зохицуулалт хараахан байхгүй.

Энэ асуудлаар Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тухай НҮБ-ын Конвенцийн нэмэлт протоколд нэгдэх асуудлыг судалж байна. Мөн Садар самуун явдалтай тэмцэх тухай хуульд интернет ашиглан садар самууныг сурталчлах, насанд хүрээгүй хүмүүсийг татан оролцуулахад эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэх асуудлыг судалж нэмэлт оруулахаар судалж байна.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд хүүхдийн эрүүл мэнд, амь насанд аюул учруулах тоглоом наадамд оруулахыг хориглоно гэж заасан. Мөн хуульд хүүхдийн эрүүл мэнд, амь насанд аюул учруулах тоглоом наадмын жагсаалтыг төрийн захиргааны төв байгууллага батлахаар тусгасан байна.

Асуулт 18. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл , интэрнет, видео,электрон тоглоом зэргээс хүүхдүүд хортой мэдээлэл олж авахаас хамгаалах чиглэл, хууль тогтоомжийн талаар

Садар самуун явдалтай тэмцэх тухай хуульд заасны дагуу эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг тусгай цэгт худалдах журамтай. Мөн энэ хуулиар албан байгууллага, гудамж, талбай, хүүхдийн байгууллага, цэцэрлэг, сургууль, окутны болон сурагчдын дотуур байр, хүнс, барааны зах, худалдаа, үзвэр үйлчилгээний газар худалдах, гар дээрээс худалдах; 18 насанд хүрээгүй хүнээр худалдуулах,18 насанд хүрээгүй хүнд худалдах, үзүүлэхийг тус тус хориглодог.

Асуулт 19.Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой аливаа үйлдлийн талаар зохих хүмүүст мэдээлэхтэй холбоотой хууль тогтоомж бусад шийдвэр байдаг уу. Хэрэв байдаг бол бүх иргэдэд мэдээлэх үүрэгтэй юу? Эсвэл энэ үүргийг тодорхой мэргэжлийн бүлэг хүмүүс гүйцэтгэдэг үү?Мэдээлээгүй тохиолдолд хариуцлага хүлээх тусгай заалт бий юу?

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомж зөрчсөн талаар мэдээлэх, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд санал болгох үүрэгтэй байхаар заасан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, эмнэлгийн мэргэжилтэн албан үүргээ биелүүлж байх үедээ гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй байгаа нь илэрхий болсон тохиолдолд цагдаагийн байгууллага, боломжгүй бол нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэх үүрэг хүлээлдэг. Мөн хуулиар шууд үүрэг хүлээдэггүй боловч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй байгаа тухай мэдээлэх эрхтэй юм. Түүнчлэн цагдаагийн байгууллага энэ талаар аливаа мэдээллийг хүлээн авч шаардлагатай арга хэмжээ авах үүрэгтэй юм.

Гомдол гаргах журам

Асуулт 20. Гэр бүл, сургууль, цэцэрлэг, цэргийн сургууль, асрамж халамж, эрүүл мэндийн үйлчилгээний газар, хорих анги, ажлын байр, спортын байгууллага, нийгэм хамт олны дунд хүүхдийн эсрэг аливаа хэлбэрийн хүчирхийлэл үйлдэж байгаа талаар гомдол гаргах журмын тухай мэдээлэх

Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу хүүхэд өөрөө буюу хүүхдийг төлөөлөн хэн ч гомдол гаргах эрхтэй. Энэ эрхийг хэрэгжүүлэхэд хүний эрх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага туслалцаа үзүүлдэг.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд хүүхэд эрхээ зөрчигдсэн гэж үзвэл өөрөө болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, бусад иргэн, байгууллагаар уламжлан эрхээ хамгаалуулахаар гомдол, нэхэмжлэл гаргах, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, нийгмийн ажилтан, бусад иргэн хүүхдийн эрх зөрчигдсэн гэж үзвэл гомдол, нэхэмжлэл гаргах тухай заасан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хохирогч өөрөө болон итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчөөрөө дамжуулан хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авхуулахаар шүүхэд хүсэлт гаргахаас гадна цагдаагийн байгууллага дээрх арга хэмжээг авхуулахаар шүүхэд хүсэлт гаргаж болохоор заасан байгаа. Мөн энэ хуульд заасан нийгмийн ажилтан, итгэмжлэгдсэн төлөөлөгч нь гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэл цуглуулах, судалгаа хийхээс гадна гомдол, мэдээллийг цагдаагийн байгууллага хүлээн авах, түүний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой тусгасан.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар тухайн хүчирхийллийн үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй бол тусгай журмыг баримталдаг.

Асуулт 21. Хүүхэд өөрөө болон хүүхдийг төлөөлөх этгээд хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар гомдол шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцож болох уу? Гомдол гаргахад эрхзүйн туслалцаа үзүүлдэг үү, ямар нөхцөлд үзүүлдэг вэ

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хохирогч нь өмгөөлөгч авах, холбогдох байгууллага албан тушаалтанд хүсэлт тавих, баримт материал шалгуулах зэрэг эрхийг хангасан бөгөөд насанд хүрээгүй хүмүүсийн үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэх бүх шатны ажиллагаанд тэдгээрийн эцэг эх, хууль ёсны төлөөлөгчөөс гадна өмгөөлөгчийг заавал оролцуулахаар тусгасан.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчоос гаргасан гомдлыг хянан шийдвэрлэхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг баримтлан, хохирогчийн гомдол, түүний өмгөөлөгч, цагдаагийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлт, холбогдох нотлох баримтад үндэслэн шийдвэрлэж, насанд хүрээгүй хохирогч оролцсон шүүх хуралдааныг хаалттай явуулах журам баримталдаг.

Асуулт 22. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн тухай гомдол гаргах боломжийн талаар олон нийтэд хандан ямар алхам хийдэг вэ

Төрийн болон төрийн бус байгууллагын сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслийн тусламжтайгаар хүүхдийг хүчирхийллээс хамгаалах талаар олон нийтэд зориулан сургалт, сурталчилгаа, бүртгэл, судалгаа, зөвлөгөө мэдээлэл, "итгэлтэй утас", хэвлэлийн мэдээ зэргийг тогтмол явуулдаг.

Асуулт 23. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой хэргийг шалгахад тусгай журам баримтладаг уу, /баримтаар нотлох журам хэрэглэдэг эсэх талаар мэдээлэл өгнө үү./

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зааснаар шүүх хохирогчийн гомдол, цагдаагийн байгууллагын ажилтан, эсхүл өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлт, бусад нотлох баримтыг үндэслэн хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарласан шийдвэрийг гаргадаг. Ингэхдээ хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн гомдлыг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор хуульд заасан арга хэмжээг авах шийдвэрийг шүүх гаргаж болохоор заасан байна. Хувь хүний нууцтай холбоотой тухайлбал, гэр бүлийн, бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой хэргийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар хаалттай шүүх хуралдаанаар хэлэлцдэг.

Асуулт 24. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар ирсэн гомдлын мөрөөр ихэнх тохиолдолд ямар арга хэмжээ авдаг вэ. /нөхөн төлбөр оногдуулах, буруутай этгээдийг шийтгэх, засан хүмүүжүүлэх, гэр бүлийн үйлчилгээ үзүүлэх г.м/

Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой гомдлыг барагдуулахын тулд холбогдох байгууллагууд сэтгэл зүй, эрүүл мэндийн хувьд хамгийн түрүүнд нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлдэг.

Эрүүгийн хууль болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн дагуу ирсэн гомдлыг хянан шалгаж, буруутай этгээдийг эдгээр хуульд заасан нөхцөл, журмаар торгох, баривчлах, засан хүмүүжүүлэх арга хэмжээг авдаг.

Харин 2005 оны 1 дүгээр сарын 1-нээс үйлчилж эхэлсэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд энэ тухай тодорхой зохицуулалтыг тусгаж өгөөд байна. Тухайлбал, гэр бүлийн хүчирхийллийн тухай мэдээллийг авмагцаа Цагдаагийн байгууллага газар дээр нь шалган тэмдэглэл хөтлөн түүнд захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар сануулах, шаардлагатай бол хүчирхийлэгчийг албадан түр саатуулах, хохирогчийг хамгаалах байранд хүргэж өгөх, эсхүл төрөл садангийн хүний хамгаалалтад өгөх зэрэг арга хэмжээг авахаар заасан. Энэхүү хууль дөнгөж үйлчилж эхлээд байгаа болохоор хэрэгжилт нь хараахан тогтворжоогүй байгаа.

Асуулт 25. Хүчирхийлэл үйлдсэн хүүхэд, насанд хүрээгүй хүмүүст хүлээлгэдэг ял шийтгэлийн тухай /хорих ял эдлүүлэх, бие махбодийн шийтгэл үзүүлэх, нийгмийн үйлчилгээ, гэмт этгээдийг засан хүмүүжүүлэх, гэр бүлийн эмчилгээ/

Насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахдаа Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан тусгай журмыг мөрддөг. Гэхдээ эрхийг нь хязгаарлах шийтгэлийг аль болох бага хэрэглэх зарчмыг баримталдаг.

Эрүүгийн хуулиар гэмт хэрэг үйлдэх үедээ арван зургаан насанд хүрсэн этгээд эрүүгийн хариуцлага хүлээх бөгөөд арван дөрвөөс арван зургаа хүртэл насны этгээд хүнийг санаатай алах, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах, хүчиндэх, бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар танхайрах гэмт хэрэг үйлдсэн бол түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Арван найман насанд хүрэхийн өмнө анх удаа хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн этгээдийг ял шийтгэхгүй хүмүүжүүлэх боломжтой гэж шүүх үзвэл түүнд энэ хуульд заасан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Асуулт 26. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг хариуцсан Засгийн газрын болон орон нутгийн байгууллагын бүтэц, механизм, үйл ажиллагааны уялдаа холбоо

Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх байгууллагын чиг үүрэг, хоорондын уялдаа холбоо нь Засгийн газрын тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдсан салбар дундын бүтэцтэй байна.

Монгол Улсын Засгийн Газрын хуулийн дагуу хүүхэд залуучуудын асуудал Шадар Сайдын эрхлэх асуудлын хүрээнд багтдагийн хувьд хүүхдийн эсрэг хүчирхийллийн салбар дундын ерөнхий зохицуулалтыг Шадар Сайдын ажлын алба хариуцаж байна. Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах бодлого, стратегийг тодорхойлох ба урьдчилан сэргийлэх асуудлыг Хууль зүй, дотоод хэргийн Яам, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх асуудлыг Нийгмийн хамгаалал, Хөдөлмөрийн Яам эрхэлдэг. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох НХХЯ нь хүчирхийлэлд өртөгчдөд үзүүлэх нийгмийн үйлчилгээг зохион байгуулах, хүчирхийллээс хамгаалах байранд тавигдах наад захын шаардлагыг тодорхойлох бүрэн эрхтэй болохыг заасан.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн холбоотой бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, зохицуулах асуудлыг Цагдаагийн ерөнхий газар, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хүүхдийн төлөө үндэсний газар зэрэг Засгийн Газрын агентлаг хариуцан энэ талаар НҮБ-ын төрөлжсөн болон Олон улсын ба үндэсний байгууллагуудтай хамтран ажилладаг.

Монгол Улсын Ерөнхий Сайдын тэргүүлдэг Хүүхдийн төлөө Үндэсний Зөвлөлийн ажлын алба-Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Хүүхдийн төлөө үндэсний газар хүүхдийн эрхийг хангах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд хүүхдийн оролцоог хангах, Төрийн бус байгууллагуудыг татан оролцуулах, орон нутаг дахь Засаг даргын агентлаг-Хүүхдийн төлөө төвөөр дамжуулан аймаг, сумын түвшинд явуулах үйл

ажиллагааг мэргэжил, аргазүйн удирдлагаар хангах үүрэгтэй байдаг.

Цагдаагийн ерөнхий газар хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх гол байгууллага бөгөөд хүчирхийллийн аливаа хэлбэрийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, шийтгэл оногдуулах зэрэг хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлдэг.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд нутгийн захиргааны бүх шатны байгууллага харьяа нутаг дэвсгэртээ бодлого, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих ажлыг зохион байгуулах, шаардагдах зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх үүрэг хүлээж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөлийг ажиллуулдаг.

Асуулт 27. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг хариуцсан Засгийн газрын тэргүүлэх байгууллага байдаг уу. Хэрэв тийм бол дэлгэрэнгүй бичих.

Засгийн Газрын зүгээс хүүхдийг хүчирхийллээс хамгаалах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх энэ чиглэлийн хууль сахиулах асуудлыг Хуульзүй, дотоод хэргийн яамны харьяа ЦЕГ түүний салбар байгууллага, хохирогчид нийгмийн үйлчилгээ үзүүлэх, нөхөн сэргээх, нийгэмшүүлэхэд чиглэсэн бодлого, стратегийг боловсруулан хэрэгжүүлэх асуудлыг НХХЯ, түүний харьяа байгууллагууд хариуцдаг.

Орон нутгийн түвшинд Засаг дарга, түүний Тамгын газар, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Хүүхдийн төлөө төв, нийгмийн ажилтнууд хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх асуудлыг хариуцаж ажилладаг.

Асуулт 28. Танай оронд хүчирхийлэлтэй тэмцэхэд зориулсан санхүүгийн болон хүн хүчний тусгайлсан нөөц хэр зэрэг байдаг, хэрэв байдаг бол хэр хэмжээг нь бичнэ үү

Засгийн газар хүчирхийлэлтэй тэмцэх арга хэмжээнд зориулсан санхүүжилтийг Улсын төсвийн удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн нийт багцад багтаан төлөвлөн хэрэгжүүлдэг. Өнөөгийн байдлаар хүчирхийлэлд өртөгчдөд туслах үүрэгтэй сургуулийн нийгмийн ажилтан 500-аад, сум, хорооны хүүхдийн эрхийн ажилтан 700, сум, хорооны цагдаа 300 гаруй хүн улсын төсвөөс санхүүжин ажиллаж байна. Түүнчлэн хүүхдийн эрхийг хамгаалах талаар үйл ажиллагаа явуулдаг 100 гаруй төрийн бус байгууллагын олон зуун ажилтан, идэвхтэн, сайн дурынхан ажиллаж байна.

Асуулт 29. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд санхүү, хүн хүчний тусгайлсан эх үүсвэр гаргадаг эсэх, тийм бол нарийвчлан бичнэ үү?

Монгол Улсын Засгийн газар “Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”(2002-2010)-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрт 8,0 тэрбум төгрөг, түүний дотор хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд 35.7 сая төгрөгийг дотоод эх үүсвэрээс зарцуулсан дүн мэдээ байна.

Засгийн газраас НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран “Хүүхэд хамгаалал” хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хамгаалах, оролцоог хангах чиглэлээр судалгаа хийх, хөтөлбөр төсөл боловсруулах, сургалт, сурталчилгаа явуулах зэрэг үйл ажиллагаанд жил бүр 200.0 мянган ам.долларыг зориулж байна. Мөн Засгийн газар хүүхдийн эсрэг хүчирхийллээс сэргийлэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын Хүүхдийн алба, Хүүхдийн хаяг тогтоох шалган хуваарлих тасаг, Хүүхдийн сургалт хүмүүжлийн тусгай төв зэргийг төсвөөс бүрэн санхүүжлүүлэн ажиллуулдаг.

Засгийн газар хүүхдийг бэлгийн зорилгоор ашиглахтай тэмцэх тухай Ёкохамагийн тунхаглалд нэгдэн “ЕСРАТ” олон улсын байгууллагад гишүүнээр элсэж, үндэсний сүлжээ байгуулан, төрийн ба төрийн бус 20 гаруй байгууллагын оролцоотойгоор үндэсний хөтөлбөр боловсруулж эхлээд байна.

Асуулт 30. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх ажилд олон улсын болон хоёр талын хандивлагчдын зүгээс хөрөнгө гаргадаг эсэх, хэрэв тийм бол хэмжээ, хэрэгжүүлдэг арга замыг бичнэ үү

Олон улсын болон төрийн бус байгууллагууд өөрийн хөрөнгө санхүү, нөөцдөө түшиглэн сонгосон бүс нутаг, орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтран хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, сургалт, судалгаа явуулах, хяналтын тогтолцоог бий болгох чиглэлээр ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын төрөлжсөн байгууллага болон Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын хамтын ажиллагааны стратеги, хөтөлбөр, мастер төлөвлөгөөнд хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлыг тусган хэрэгжүүлдэг.

Их Британий Хүүхдийг Ивээх сан 2000 оноос хойш жил бүр 25-30 мянган ам.долларыг Хүүхдийн эсрэг хүчирхийлэл ба түүнээс хамгаалах хөтөлбөрт зарцуулж байна. Тухайлбал; Хүчирхийллийн эсрэг үндэсний төвд Хүүхэд хамгааллын нэгж байгуулан бэхжүүлэх, Баянхонгор ба Дорнод аймгийн цагдаагийн хэлтэст хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй ажиллах мэргэжилтнүүдээс бүрдсэн багийг турших ба тэдний чадавхийг бэхжүүлэх, олон нийтийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх, төрийн ба төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, оролцоог нэмэгдүүлэх зэрэг үйл ажиллагааг явуулж байна.

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах байр ажиллуулахад Дэлхийн Зөн, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг; хүчирхийлэлд өртсөн хүүхдийг нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулахад "АДРА" олон улсын байгууллага; хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар олон нийтийн ойлголт хандлагыг дээшлүүлэх, сургалт, сурталчилгаа явуулахад Хүүхдийг ивээх сан, (Англи) Норвегийн тусламжийн байгууллага; хүчирхийлэлд өртсөн хүүхдээс мэдүүлэх авах тусгай байрыг Цагдаагийн байгууллагын дэргэд ажиллуулахад Нээлттэй нийгмийн хүрээлэн зэрэг олон байгууллага жил бүр тодорхой санхүүжилт гарган өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр нь олон нийтийн оролцоонд тулгуурласан, хэрэгцээнд нийцсэн байдгаараа онцлогтой. Тэдний дэмжсэн төсөл, хөтөлбөрийн дүнд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг үндэсний төрийн бус байгууллагуудын чадавх бэхжиж байна.

Асуулт 31. Танай орон хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд бусад оронд тусалдаг эсэх; Хэрэв тусалдаг бол нарийвчилсан мэдээлэл өгнө үү

Монгол Улс 1950-иад онд Солонгосын, 1980-аад онд Афганистаны өнчин хүүхдүүдэд, 1990-ээд онд Чернобылийн гамшигт өртсөн хүүхдүүдэд, 2004 онд ОХУ-ын Беслан хотын хүүхдүүдэд тусалсан зэрэг түүхэн уламжлалаа үргэлжлүүлэн 2005 онд Цунамийн аюулд өртсөн хүүхдүүдэд туслах аян эрчимтэй өрнөж байна.

Асуулт 32. Танай оронд хүний эрхийн Үндэсний Комисс, омбудсмен, хүүхдийн эрхийг хамгаалах хүний эрхийн тусгайлсан байгууллага зэрэг хүний эрхийн үндэсний байгууллага байгаа эсэх, хэрэв байдаг бол хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой гомдлыг хүлээн авч барагдуулахад ямар үүрэг роль, эрх мэдэлтэй вэ?

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс хуулийн дагуу энэ асуудлыг хүлээн авч, барагдуулан шийдвэрлэдэг. Хүний эрхийн үндэсний комиссын нэг гишүүн Хүүхдийн төлөө Үндэсний Зөвлөлд сонгогдон ажилладаг.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт омбудсмен ажиллуулах асуудлыг тусган оруулж, бэлтгэлийг хангаж байна.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд заасны дагуу Хүүхдийн төлөө үндэсний байгууллага хүүхдийн талаар явуулах төрийн бодлого, хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах зорилго бүхий байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, зөвлөгөө өгөх, арга зүйгээр хангах, хүүхдийн асуудал эрхэлсэн ажилтны мэдлэг, үр чадварыг дээшлүүлэх, дадлагажуулах, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, санал боловсруулах, хүүхдийн эрхийн талаар мэдээлэл цуглуулах, судалгаа явуулах, мэдээллийн сан бүрдүүлэх, нэгдсэн сүлжээ байгуулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Асуулт 33. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудал хариуцсан парламентын Тусгай хороо зэрэг байгууллага, бүтэц бий эсэх,

УИХ дахь Хүний эрхийн дэд хороо болон Хууль зүйн ба Нийгмийн бодлогын байнгын хороодын үйл ажиллагааны хүрээнд энэ асуудал хамаарагддаг.

Асуулт 34. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар парламентаас ойрын үед санаачлан хийсэн ажлууд байгаа бол нарийвчлан бичнэ үү.

УИХ-аас;

- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах, ажилд авах насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 182, 138 дугаар Конвенцийг соёрхон баталсан. (2000, 2002)*
- Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын Конвенцийн Хүүхдийг худалдах, садар самуун болон сексийн сурталчилгаанд ашиглагдахаас хамгаалах тухай болон Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулах явдлаас урьдчилан сэргийлэх тухай Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн нэмэлт протоколуудыг 2002 онд соёрхон баталсан*
- Хүүхдийг хамгаалах, улс хооронд үрчлэх асуудлаарх олон улсын Конвенцийг 1999 онд соёрхон баталсан*
- Хүүхдийн Эрхийг Хамгаалах тухай хуулийг 1996 онд баталсан*
- Гэр бүлийн тухай хуулийг 1999 онд шинэчлэн баталсан*
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд 2003 онд нэмэлт өөрчлөлт оруулсан*
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 2004 он баталсан*
- Төрөөс гэр бүлийн хөгжлийг дэмжих талаар баримтлах бодлого гаргасан. (2004 он)*
- Хүн амын хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлого гаргасан. (2004 он)*
- Хүүхэд, өсвөр үеийнхний төлөөлөгчидтэй парламентын гишүүдийн нээлттэй хэлэлцүүлэг, ярилцлага, онол практикийн бага хурал зэргийг жил бүр Олон улсын Хүүхдийн нэвтрүүлгийн өдрөөр сэдэвчлэн явуулдаг уламжлалтай болсон. Тухайлбал “Хууль зөрчсөн хүүхэд” сэдвээр 2003,2004 онд УИХ-ын Байнгын Хороод өсвөр үеийнхний төлөөлөгчидтэй нээлттэй хэлэлцүүлэг явуулсан.*
- УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос Хүүхдийг хил дамжуулан худалдагдах, бэлгийн зорилгоор ашиглагдахаас хамгаалах талаар мэргэжлийн байгууллагын удирдлагатай ярилцлага зохион байгуулсан (2004.9 сар)*
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөөг УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хороо батлаад байна. (2005.01 сар)*

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд хандах иргэний нийгмийн хандлага ба роль. Энэ бүлгийн зорилго нь хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой нийгмийн үйл ажиллагааны талаар мэдээлэл авахад оршино.

Асуулт 35. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд иргэний нийгмийн үр нөлөөтэй санаачлага. Үүнд судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, эмэгтэйчүүд, оюутны байгууллага, олон нийт, шашны болон хүүхэд залуучуудын хөдөлгөөн, дотоодын болон олон улсын төрийн бус байгууллага хөдөлгөөний голлодог үйл ажиллагаа

Сүүлийн жилүүдэд хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь олон нийтийн анхаарал татсан асуудал болж, энэ асуудлаар төрийн бус болон олон улсын байгууллагууд судалгаа шинжилгээ хийх, халамжийн үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөө өгөх, олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, сургалт сурталчилгааны үйл ажиллагаа явуулах, эрх зүйн орчинг боловсронгуй болгоход шийдвэр гаргах түвшинд нөлөөлөх зэрэг үйл ажиллагааг идэвхтэй явуулах болсон. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь гэр бүл, сургуулийн орчинд илүү их байгаа нь судалгаагаар нотлогдсон бөгөөд өртөгчдөд тусламж дэмжлэг үзүүлэхэд иргэний нийгмийн байгууллагууд зохих хувь нэмэр оруулж байна.

- Хууль болон бодлогын баримт бичгийг боловсруулах, хэрэгжүүлэхэд Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо, Монголын хүүхдийн эрхийн төв, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн хэрэгжилтийг хянах Үндэсний Сүлжээ, Монголын эмэгтэйчүүдийн холбоо, "Гал голомт" хөдөлгөөн, "Зохистой хөгжил жендэр төв", Хүүхдийн төлөө төрийн бус байгууллагуудын үндэсний эвсэл тэргүүтэй үндэсний төрийн бус байгууллага, Их Британий хүүхдийг ивээх сан, НҮБ-ын Хүүхдийн сан, Дэлхийн Зөн, Азийн сан, Монголын нээлттэй нийгмийн хүрээлэн зэрэг олон улсын хандивлагч байгууллагууд идэвхтэй оролцож ирлээ.
- Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх нийгмийн халамж үйлчилгээний чиглэлээр Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Хүүхэд залуучуудын хөгжлийн төв, Хүйсийн тэгш эрхийн төв, Хүүхдийг ивээх сан, Дэлхийн Зөн, Кристина Нобелийн хүүхдийн сан, "Бадамлянхуа" төв, АДРА, Норвегийн тусламжийн байгууллага, Ватиканы төлөөлөгчийн газар зэрэг байгууллага идэвхтэй ажиллаж байна.
- Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн хохирогч хүүхдэд ээлтэй эрх зүйн тогтолцоо бүрдүүлэх зорилгоор Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Хүйсийн тэгш эрхийн төв, Хүүхдийг ивээх сан, Дэлхийн зөн, Монголын нээлттэй нийгэм хүрээлэн зэрэг байгууллага хамтран ажиллаж байна.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдийн эрхийг хамгаалах, хүчирхийлэл дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбоо, Тахир дутуу эмэгтэйчүүдийн холбоо, хөдөлмөр эрхэлж буй хүүхэд, хорих ял эдэлж буй насанд хүрээгүй хүмүүсийг хүчирхийлэл дарамтаас сэргийлэх, нийгэмшүүлэх, дэмжлэг тусалцаа үзүүлэх чиглэлээр Хүүхдийн эрхийн төв, Японы Энхтайвны салхи, "Зохистой хөгжил-Жендэр

төв", Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага, хүүхдийн "Мандах" холбоо зэрэг олон байгууллага ажилладаг болов.

Асуулт 36. Засгийн Газраас дээрх үйл ажиллагаанд яаж дэмжлэг үзүүлдэг, иргэний нийгмийн санаачлагуудыг уялдуулан зохицуулах талаар ямар чармайлт гаргадаг, мөн Засгийн газраас энэ чиглэлээр гаргасан санаачилга

Засгийн газрын зүгээс хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, гүйцэтгэх шатны байгууллагуудад удирдамж чиглэл өгөх, санхүүгийн тодорхой дэмжлэг үзүүлэх эрмэлзэлтэй байдаг.

Засгийн Газрын тухай хуульд төрийн байгууллагын зарим тодорхой чиг үүргийг Засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлж болно гэж заасны дагуу Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, "Гал голомт" үндэсний хөдөлгөөн зэрэг байгууллагатай гэрээ байгуулан хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хүчирхийлэлд өртөгчдөд туслах үйл ажиллагааг дэмжин тусалж, хамтран ажиллаж байна.

Төрийн болон төрийн бус байгууллагууд хамтарч үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргах түвшинд нөлөөлөх, цогц үйлчилгээ үзүүлэхэд мэргэжлийн бүлгүүдийг татан оролцуулахаар, Хүүхдийн төлөө төрийн бус байгууллагуудын үндэсний эвсэл, Хүүхдийн хамгааллын сүлжээ зэргийг байгуулан ажиллаж байна.

Асуулт 37. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үүрэг ролийн талаар

- Монголын үндэсний болон орон нутаг, хувийн хэвшлийн телевизийн хөтөлбөрт хүүхдийн асуудал, түүн дотор хүүхдийг хүчирхийллээс сэргийлэх сэдэв тогтмол тусч байдаг. Цаашид хүүхдийн эрхийг ойлгох, хангах, хамгаалахад чиглэсэн мэдээлэл, нэвтрүүлгийг өргөжүүлэх чиглэлийг барьж байна. Хүүхдэд зориулсан сургалт, танин мэдэхүйн болон эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, нийт иргэдэд зориулсан нэвтрүүлгийг Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт "Хүүхдийн оролцоо, мэдээллийн хүртээмж" бүлэг болгон тусгаад хэрэгжүүлж байна. Хүүхдэд зориулсан хувийн хэвшлийн нэлээд хэдэн сонин сэтгүүл тогтмол гардаг болов.*

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаанд хүүхдийн оролцоо талаар

Асуулт 38. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх талаар санал гаргах, бодлого, хөтөлбөр, боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавихад хүүхдийн оролцоог хангаж байгаа талаар. Дээрх ажилд оролцдог хүүхдүүдийн нас болон бусад онцлогийн тухай.

Сүүлийн жилүүдэд хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагыг бэхжүүлэх, тэдний оролцоог өргөтгөх, хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагын тогтолцоог хөгжүүлэхэд анхаарч байна.

Хүүхдийн үндэсний болон орон нутгийн чуулга, уулзалтууд болж өсвөр үеийнхэн аль ч түвшинд хүүхэдтэй холбоотой асуудлаар

саналаа хэлэх, төр олон нийтийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөх, хамтран ажиллах бүрэн чадвартайг монголын нийгэм хүлээн зөвшөөрч, тэднийг анхааралтай сонсдог болсон. Тухайлбал Нэг ертөнц – өсвөр үе байгууллага Мини засгийн газар, Мини парламент, Мини НҮБ, Хүүхдийн Форум зэрэг арга хэмжээг зохион байгуулсан юм. Эдгээрийн үндсэн дээр 12-18 насны хүүхэд, өсвөр үеийнхэн өөрсдийн оролцооны байгууллагын стратегийн баримт бичгийг боловсруулж гаргалаа.

Монгол Улсын Засгийн газраас 2004 онд Хүүхдийн асуудлаархи үндэсний дээд хэмжээний чуулга уулзалтын өмнө Хүүхдийн форумыг зохион байгуулахад хүүхдүүд хүчирхийллийн эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ дүгнэлт өгч, зөвлөмж гаргасан.

Асуулт 39. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэргийг шүүхээс хянахдаа, шүүхийн үйл ажиллагаа, нотлох баримтыг үнэлэхэд хүүхэд оролцсон тохиолдол байна уу.

Тийм тохиолдол байхгүй.

Асуулт 40. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх үйл хэрэгт хүүхдийн оролцоог дэмжихэд зориулсан хөрөнгийн төрөл, түүний хэмжээ, эх үүсвэрийн талаар

Монгол улсын Засгийн газраас хүүхдийн чуулганыг зохион байгуулахад удаа дараагийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудаас 2000-2003 онд хамтран хэрэгжүүлсэн “Монголын өсвөр насны охид, хөвгүүдийн аж байдлыг сайжруулах төсөл”-ийн хүрээнд “Хүүхэд хүүхэддээ” сэдэвт цуврал киног хүүхдүүд өөрсдөө санаачлан бүтээж, сурталчлахад 16.0 мян ам.долларын санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.

Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагууд хүчирхийлэлтэй тэмцэх талаар төсөл хэрэгжүүлэх, сонин гаргах, радио телевизийн нэвтрүүлэг явуулах, олон нийтийг уриалсан компани ажил өрнүүлэхэд ивээн тэтгэгчдийн дэмжлэг авч байна. Жишээ нь; Монголын хүүхэд залуучуудын хөгжлийн төвөөс эмзэг бүлгийн хүүхдүүдэд зориулсан сонин хэвлүүлэхэд 2003 онд НҮБ-ын Хүн амын сан, Голландын Элчин Сайдын яам, Азийн хөгжлийн банкнаас 14 мянган еврогийн тусламж үзүүлэв. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө үндэсний газар хүүхдийн оролцооны байгууллагуудыг дэмжин ажиллах байр танхим, тоног төхөөрөмжөөр ханган тодорхой дэмжлэг үзүүлэх болсон.

ТАВДУГААР БҮЛЭГ

Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх хөтөлбөр, бодлого

Асуулт 41. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх Засгийн газрын бодлого, хөтөлбөр бий юу, Хэрэв тийм бол энэ бодлогод жөндөрийн холбоотой зүйл хэрхэн тусгагдсан бэ?

Монгол Улсын төрөөс Хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого болон Гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлогод хүүхдийг хүчирхийлэх, хэрцгийлэх, гэмт хэрэг, садар самууны зорилгоор ашиглах зэрэг болзошгүй аюулаас хамгаалах зорилт дэвшүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газраас Хүний эрхийг хангах хөтөлбөр, Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр, Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр, Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр болон орон нутгийн дэд хөтөлбөрүүдэд хүүхдийг хүчирхийллээс хамгаалах асуудал туссан бөгөөд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааг өргөжүүлэх зорилт дэвшүүлсний гадна хүйсийг онцолсон заалтууд туссан.

Асуулт 42. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөрийг Засгийн газар хэрэгжүүлдэг эсэх, хэрэгжүүлдэг агентлаг ажилладаг уу? Тийм бол тэдгээр хөтөлбөрийн тайлан, вэб хаяг бусад зүйлийг хавсаргаж хөтөлбөрүүд нь хүчирхийллийн ямар орчин нөхцөл болон хэлбэрт чиглэж ажилладаг болохыг хавсралт-1 хүснэгтийн дагуу бичнэ үү

- Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг Засгийн Газар 2002 онд баталж, хэрэгжүүлэх чиг үүргийг **Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг**-Хүүхдийн төлөө Үндэсний Газарт хариуцуулсан.
- Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийг Засгийн Газар 1999 онд баталж, хэрэгжүүлэх чиг үүргийг Цагдаагийн ерөнхий газарт хариуцуулсан байна.

Монгол Улсын төрийн бодлогыг тодорхойсон бодлого, хөтөлбөрт хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудал хэрхэн туссаныг хавсралт 1-д харуулав. Үүнд;

Эрхийн акт/ Орчин	Гэр бүл	Сур гууль	Олон нийтийн	Ажлын байр	Хууль сахиулах байгууллага	Бусад
Хүн амын талаар төрөөс баримтлах бодлого	✓	✓	✓	✓	✓	✓
Гэр бүлийн хөгжлийг дэмжих бодлого	✓	✓	✓	✓	✓	✓
Төрөөс хүүхэд залуучуудын талаар баримтлах бодлого	✓	✓	✓	✓	✓	✓
Монгол улсад хүний эрхийг хангах хөтөлбөр	✓	✓	✓	✓	✓	✓
Жендэрийн тэгш байдлыг хангах	✓	✓	✓	✓	✓	✓

үндэсний хөтөлбөр						
Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр	✓	✓	✓	✓	✓	✓
Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр	✓	✓	✓	✓	✓	✓

Асуулт 43. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх бодлого, хөтөлбөрийн нөлөөлөлд Засгийн Газар мониторинг хийдэг үү? Тийм бол мониторингийн тогтолцооны талаар дэлгэрэнгүй мэдээлэл, материал, веб хаягийг ирүүлнэ үү

Засгийн Газрын тогтоолоор батлагдсан шийдвэр, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн тайланг хагас бүтэн жилээр гарган байгууллага, олон нийтэд түгээдэг. Тухайлбал Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг жил бүр УИХ-д тайлагнадаг.

Уг хөтөлбөрийн 2002-2004 онд хэрэгжүүлсэн дүнг хүүхдийн үндэсний форумаар хэлэлцүүлж, үнэлгээ дүгнэлтийг Хүүхдийн асуудлаарх үндэсний дээд хэмжээний чуулга уулзалтад танилцуулсан.

Яам бүрт мэдээлэл, хяналт шинжилгээний газар ажилладаг. Эдгээр газрууд нь Засгийн газрын бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд мониторинг хийдэг. Мөн Засгийн газрын хэрэг эрхлэх газарт мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс бий. Энэ хэлтэс яамдын мониторингийг хянаж, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажилладаг.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө үндэсний газар хүүхдийн эрхийн хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ хийж эхэлж байгаа.

Засгийн газрын байгууллагуудын холбогдох мэдээллийг <http://www.open-government.mn>; хаягаар танилцах боломжтой.

Асуулт 44. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой олон улсын зохицуулалттай үйл ажиллагаанд танай Засгийн газар оролцдог уу. Хэрэв тийм бол тодорхой бичнэ үү?

Монгол Улс хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх зорилгоор олон улсын конвенци, эрхзүйн хэм хэмжээнд нэгдэн орох, олон улсын болон бүсийн хэмжээний уулзалт, зөвлөлгөөнөөс гаргасан Тунхаглал, Үйл ажиллагааны хөтөлбөр, санал санаачилгыг дэмжих зэргээр олон улсын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож хамтарч ажилладаг. Тухайлбал, Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын Конвенци, энэхүү конвенцийн Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцохоос сэргийлэх тухай, Хүүхдийг худалдах, биеэ үнэлэх, садар самуунд татагдахаас хамгаалах тухай Нэмэлт Протоколууд, Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар

хамтран ажиллах тухай Гаагийн Конвенци, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох болон нэн даруй устгах тухай, Ажилд авах насны доод хязгаарын тухай ОУХБ-ын Конвенциудад нэгдсэн.

Монгол Улс хүүхдийг бэлгийн зорилгоор ашиглахтай тэмцэх тухай Стокгольмийн үйл ажиллагааны төлөвлөгөөний үзэл санааг хүлээн зөвшөөрч, Ёкохамагийн тунхаглал, Хүүхдийг бэлгийн зорилгоор ашиглах, хил дамжуулан худалдаалахын эсрэг олон улсын байгууллагын ЕСРАТ сүлжээнд нэгдэн, Ази, Номхон далайн бүсийн Сайд нарын удаа дараагийн уулзалтын амлалт, зөвлөмжийн үзэл санаа, зарчмыг үндэслэн Үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлдэг.

Хүүхэд, өсвөр үеийнхний оролцоог дэмжсэн олон улс, бүс нутгийн арга хэмжээнд монголын өсвөр үеийнхний төлөөлөл амжилттай оролцож байгаа бөгөөд сүүлийн хоёр жилийн дотор манай төлөөлөгч нэг хүүхэд НҮБ-ын Хүүхдийн сангийн нарийн бичгийн дарга нарын хуралд оролцож, илтгэл тавьсан мөн төлөөлөгч хүүхдүүд бүс нутгийн хэмжээний удаа дараагийн уулзалт, арга хэмжээнд оролцсоны дүнд Хөдөлмөр эрхлэгч хүүхдийн байгууллага Дэлхийн хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн холбоонд гишүүнээр, сурагч Анарболд Дэлхийн хүүхдийн парламентын гишүүнээр тус тус элсэн хамтран ажиллаж байна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

Мэдээлэл, тоо баримт цуглуулах, анализ судалгаа хийх

Энэ бүлэгт хүүхдийн эсрэг хүчирхийллийн тухай мэдээлэл болон мэдээллийн тогтолцоо, төлөвлөлт, хяналт, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд хууль зүйн болон хөтөлбөрийн нөлөөлөл зэргийг тоймлон харуулах юм.

Асуулт 45. Танай оронд хүчирхийлэлд өртсөн хүүхэд, гаралт ихтэй хүчирхийллийн хэлбэрийг илрүүлэх болон бусад холбогдох асуудлаарх хүн амд суурилсан судалгааг сүүлийн 5 жилд явуулсан эсэх, Тийм бол судалгааны тухай дэлгэрэнгүй бичих буюу жагсаалтыг гаргах, эсвэл судалгааны тайланг хавсаргах

Манай улс сүүлийн 5 жилийн байдлаар хүүхдийн хүчирхийллийн нөхцөл байдлын талаар үндэсний түвшний цогц суурь судалгаа хараахан хийгээгүй байна. Гэвч салбарын яам, агентлаг, үндэсний болон олон улсын төрийн бус байгууллага хамтран донор байгууллагын дэмжлэгтэйгээр хэсэгчилсэн судалгааг хийсэн байна. (Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотойгоор 2000 оноос хойш хийсэн зарим судалгааны товч танилцуулгыг хавсаргав.)

Асуулт 46. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, түүний эцэг эхтэй ярилцаж судалгаа хийсэн эсэх, Тийм бол түүний тухай

Хүчирхийлэлд өртсөн ба өртөж болзошгүй хүүхэд, болон тэдний гэр бүлийн судалгааг энэ чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг байгууллага, нэгжүүд түлхүү хийдэг байна. Мөн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хүүхдийн төлөө үндэсний газар, Цагдаагийн ерөнхий газрын Хүүхдийн тасаг, Хүүхдийн хаяг тогтоох, шалган хуваарилах байр, Хүүхдийн сургалт хүмүүжлийн тусгай төв, Нялхсын клиник сувилал зэрэг улсын төсвөөс санхүүждэг төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагууд өөр өөрийн чиглэлээр хийсэн судалгааг үйл ажиллагаандаа хэрэглэж байна. Орон нутгийн ба анхан шатны төр, засгийн байгууллага болон дээрх байгууллагууд тус тусын чиглэлээр судалгаа хийхдээ хүүхдийн ар гэрийн байдлыг хамтад нь нэлээд нарийвчлан авч үздэг.

Асуулт 47. Танай Засгийн Газар сүүлийн 5 жилд хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа шинжилгээний төсөл хэрэгжүүлсэн буюу захиалан хийлгэсэн үү. Тийм бол түүний сэдэв зорилго нь юу байсан бэ, Судалгааны үр дүнг хаана хэрэглэж болох тухай дэлгэрэнгүй мэдээлэл

Монгол Улсын Засгийн газраас НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын дэмжлэгээр “Өсвөр үеийнхний жирэмслэлт-Монголд”, “Монголын өсвөр үеийнхний хэрэгцээг тодорхойлох” зэрэг хэд хэдэн судалгааг хийсэн байна.

Эдгээр нь өнөөгийн хүүхэд, өсвөр үеийнхний тулгамдсан хэрэгцээ тэр дундаа тэдний эсрэг байгаа хүчирхийлэл, доромжлол, хайхрамжгүй байдлыг гаргасан үр дүнтэй судалгаа болсон байна. Түүний мөрөөр хэд хэдэн хуулийн заалт, төсөл, хөтөлбөр боловсруулаад хэрэгжиж байна.

Асуулт 48. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх хууль зүйн арга хэмжээнд судалгаа шинжилгээний ажлын үр дүн нөлөөлсөн эсэх, Тийм бол дэлгэрэнгүй бичиж, баримт хавсаргана уу

Хүний эрхийг хамгаалах эрхзүйн орчныг боловсронгуй болгож байгаа энэ цаг үед тухайн асуудлаар хийсэн судалгаа шинжилгээ нь шинээр боловсруулах болон нэмэлт өөрчлөлт оруулж байгаа хууль тогтоомжид гол үндэслэл болдог.

Сүүлийн жилүүдэд хийсэн судалгаа шинжилгээний ажлын үр дүн нь эрх зүйн орчныг сайжруулах, бодлого хөтөлбөр боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийг хянахад суурь мэдээлэл болон ашиглагдах нь түгээмэл болж байна.

Асуулт 49. Танай Засгийн Газарт хүчирхийллийн улмаас болон түүний нөлөөгөөр нас барсан хүүхдийн бүртгэлийг хөтөлдөг албан ёсны тогтолцоо бий юу

Хүчирхийллийн улмаас нас барсан хүүхдийн нас баралт бүрийг бүртгэж, шалтгааныг судалдаг тогтолцоотой. Бусдын гарт амиа алдах тохиолдлыг эрүүгийн хуулийн дагуу Улсын Мөрдөн Байцаах Газар бүртгэн шалгаж тогтоодог. Улсын Дээд Шүүхийн статистик мэдээнд хүүхэд хохирсон хэргийг эрүүгийн хэргийн зүйлчлэлээр

гаргадаг бөгөөд энэ нь зөвхөн яллах дүгнэлттэй шүүх хуралдааны хэлэлцэж шийдсэн хэргийн хүрээг хамардаг байна.

Асуулт 50. Хүчирхийллийн улмаас болон түүний нөлөөтэй нас баралтын статистик тайланг хэвлэн гаргадаг уу? Тийм бол бусдын гарт амиа алдсан 18-аас доош насны хүмүүсийн эзлэх хувь

Хүчирхийллийн нөлөөтэй нас баралтын тухай статистик тайланг Цагдаагийн байгууллагаас албан ёсоор хэвлэн нийтэлдэггүй бөгөөд гэмт хэргийн улмаас нас барсан хүүхдийн талаар дараах мэдээллийг гаргасан байна. Үүнд;

№	2000	2001	2002	2003	2004	ДҮН
Тоо	112	95	89	120	134	1527

Асуулт 51. Танай Засгийн газар хүчирхийллийн улмаас болон түүний нөлөөтэй нас баралтын үндэсний тайланг хэвлэн нийтлэхдээ дараахь үзүүлэлтийг мэдээлдэг үү? Мэдээлэл бүрийг тэмдэглэ.

(Хүйс, нас, яс үндэс, үхлийн шалтгаан, бусдын гарт амь үрэгдсэн, амиа хорлосон, тодорхойгүй, гаднын нөлөөгөөр амь үрэгдсэн, уг явдал хаана болсон, хаяг, болсон газрын дүр зураг, болсон цаг хугацаа, огноо, хохирогч ба гэмт этгээдийн харилцаа, бусад зүйл)

Цагдаагийн байгууллагаас дээрх асуултын дагуу нэгдсэн тайлан гаргаж нийтэд мэдээлдэггүй боловч хүчирхийллийн үйлдэлтэй хэргүүдийн талаар дээрх асуулгын дагуу тодорхой мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр гардаг.

Асуулт 52. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүртгэгдсэн тохиолдлын тоог 2000, 2001, 2002, 2003 оноор гаргах

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу энэ оноос эхлэн ийт хэргийг бүртгэж эхэлж байна.

Асуулт 53. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүртгэгдсэн болон шийтгэгдсэн гэмт хэргийн тоо, хэргийн төрлөөр, 2000, 2001, 2002, 2003 оноор гаргах

Уг асуулга судалгааны 52, 53 дугаар асуултын дагуу бүртгэл, тайланг цагдаагийн байгууллагаас насанд хүрээгүй хүмүүсийн хувьд нарийвчлан гаргадаггүй. Харин гэмт хэрэгт өртсөн болон, гэмт хэргийн улмаас нас барсан хүүхдийн холбоотой дараахь статистик байна. Үүнд;

Гэмт хэрэгт өртөж, гэмт хэргийн улмаас бэртэж гэмтсэн хүүхдийн тоо ;

№	2000	2001	2002	2003	2004
Хүчин	34	46	48	47	43
Иргэдийн эрх чөлөөний эсрэг	93	63	75	76	70
Булаалт, дээрэм	64	62	65	64	62
Дүн	191	171	188	187	175

(Эх сурвалж; ЦЕГ-ын мэдээлэл 2004он)

Зөвхөн шүүхээр хэлэлцэгдсэн хэргийн хэмжээнд эрүүгийн хэргийн зүйлчлэлээр гаргасан хүүхдийн эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн мэдээ. Улсын дээд Шүүхийн Судалгааны төвийн мэдээ /2004.11 сар/

	2001	2002	2003
Хууль бусаар үр хөндүүлсэн хүүхэд;	3	0	2
Хаяж төөрүүлсний улмаас хохирсон хүүхэд ;	3	2	1
16 нас хүрээгүй хүнтэй хурьцал үйлдсэний улмаас хохирсон хүүхэд;	6	9	5
Нийт	12	11	8

ДОЛООДУГААР БҮЛЭГ

Олон нийтийн мэдлэг, сурталчилгаа, сургалт

Асуулт 54.

Засгийн газраас сүүлийн 5 жилд Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар ухуулан таниулах, мэдээлэх, урьдчилан сэргийлэх талаар ямар нэгэн компани ажлыг зохион байгуулсан уу?

Монгол Улсын Засгийн газар жил бүр олон нийтийг хамарсан тодорхой арга хэмжээг зохион байгуулдаг. Тухайлбал 2000 оныг Хүүхдийн хөгжлийг дэмжих жил, 2003 оныг Тахир дутуу иргэд, хүүхдийг дэмжих жил, 2004 оныг Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил болгосон ба 2001 онд НҮБ-ын Ерөнхий ассамблейн тусгай чуулганыг угтаж “Хүүхдийн сайн сайхны төлөө За гэж хэлье” гарын үсэг зурах дэлхий нийтийн хөдөлгөөнд нэгдэж, “Хүүхдээ хайрлая, хамгаалъя, сонсьё, дэмжье” үндэсний компани ажлыг зохион байгууллаа.

- *Олон улсын Хүүхдийн нэвтрүүлгийн өдрийг Монгол Улс 1994 оноос хойш жил бүр тэмдэглэж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий Сайд бөгөөд Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлийн тэргүүн болон бусад шийдвэр гаргагчид хүүхэд, олон нийттэй уулзаж, санал солилцон, үр дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчилдаг уламжлал тогтов.*
- *Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хүүхдийн төлөө үндэсний газар НҮБ-ын Хүүхдийн сан, Норвегийн тусламжийн байгууллага болон бусад төрийн бус байгууллагатай хамтран хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар сурталчилгааны үйл ажиллагаа өрнүүлж, гарын авлага ба эвхмэл ном, товхимол зурагт хуудас, хуанли, зэргийг хэвлүүлж нийтэд түгээх ажлыг тогтмол зохион байгуулдаг.*
- *Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг өрнүүлэхэд төрийн бус байгууллагууд илүү идэвх санаачлагатай ажилладаг.*

Асуулт 55. Компанит болон сурталчилгааны ажлыг ямар хэрэгсэл ашиглаж явуулсан бэ

Хэвлэл,	✓
Радио	✓
Телевиз	✓
Театр	✓
Сургууль	✓
Бусад	✓

Асуулт 56. Танай Засгийн газар сүүлийн 5 жилд хүүхдийн хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар сургалт явуулж, сургалтын хөтөлбөрийг ивээн тэтгэсэн үү. Тийм бол хавсралт -2-ыг бөглөнө үү.

	Урьдчилан сэргийлэх	өртөгчдийг хамгаалах	Хохирлыг барагдуулах	Нөхөн сэргээх	Торгох
Эмнэлгийн ажилтан	✓	✓		✓	
Нийгмийн эрүүл мэндийн ажилтан	✓	✓	✓	✓	✓
Нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид	✓	✓	✓	✓	
Багш боловсролын ажилтан	✓	✓		✓	
Шүүхийн ажилтан		✓	✓	✓	✓
Цагдаагийн ажилтан	✓	✓	✓	✓	✓
Хорих газрын ажилтан	✓	✓	✓	✓	✓
Насанд хүрээгүй гэмт хэрэгтэн, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид	✓	✓	✓	✓	✓
Бусад (олон нийт)	✓	✓	✓	✓	✓

Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотойгоор 2000 оноос хойш хийсэн зарим судалгааны товч танилцуулга

Судалгааны нэр, хугацаа	Зорилго	Үр дүн	Хийсэн байгууллага	Захиалагч
Нийслэлийн захын хороолол болон бусад хотуудад амьдарч байгаа хүүхдийн амьдралын тухай (2001-2002)	Нийслэлийн хамгийн захын, хүн амын нягтшил, шилжилт хөдөлгөөн их нутаг дэвсгэрт амьдарч байгаа хүүхдүүдийн байдлыг судлан тэдэнд ээлтэй орчин бий болгоход учирч байгаа саад бэрхшээлийг тодруулах	Захын хорооллын хүүхдүүдэд хүрч байгаа нийгмийн суурь үйлчилгээ ний чанар, хүртээмжид нөлөөлж байгаа хүчин зүйлийг тодруулж, мэдээллийн эх үүсвэртэй болсон	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хүүхдийн төлөө Үндэсний Газар, Хүүхдийг ивээх сан, НҮБ-ын Хүүхдийн сан	Засгийн газрын хэрэгжүүлэгч-агентлаг Хүүхдийн төлөө Үндэсний газар
Монголын өсвөр үеийнхний хэрэгцээг судлах судалгаа (2000 он)	Анкетын судалгаа, фокус бүлгийн ярилцлага зэргээр өсвөр үеийнхний хэрэгцээг олон талаас нь судлах, тодорхойлох	"Өсвөр насны охид хөвгүүдийн аж байдлыг сайжруулах нь "сэдвээр НҮБ-ын төрөлжсөн агентлагуудын хамтран хэрэгжүүлэх 3 жилийн төслийн	Эрүүл мэндийн яам, НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын Монгол дахь суурин төлөөлөгчдийн газар, Монголын хүүхэд	Эрүүл мэндийн яам

	явдал байсан бөгөөд уг төслийн үе шат бүхэнд өсвөр үеийхний оролцоо онцгой чухал байв.	үндэслэл болсон.	залуучуудын хөгжлийн төв	
Алт олборлогч хүүхдүүдийн талаар хийсэн судалгаа (2002 он)	Албан ба албан бус аргаар алт олборлож байгаа хүүхдүүдийн тоо, цар хүрээг гарган, ажиллаж байгаа хүүхдүүдийн шинж байдал, хөдөлмөрийн нөхцөлийг судлах, түүнчлэн хүүхдийг хүнд хөдөлмөрөөс татан гаргах, алт олборлох үйл явцын эрхзүйн орчныг бүрдүүлэхэд туслах	Дэвшүүлсэн зорилтуудын дагуу 6-18 насны алт олборлодог 122 хүүхдээс авсан мэдээллийг нэгтгэн дүгнэлт зөвлөмж боловсруулж ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийг устгах нэгжийн орны хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний үндэслэл болсон.	Монгол улсын их сургуулийн Хүн ам зүйн сургалт судалгааны төв	Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр, Засгийн газар
Улаанбаатар хотын захууд дээр хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн нөхцөл байдал (2002 он)	Хүүхдийг тэвчишгүй хөдөлмөрөөс хөндийрүүлж, эрхийг сэргээх, хөдөлмөр эрхлэх, эрсдэлээс хамгаалах чиглэлээр ОУХБ-ын үйл ажиллагааны төлөвлөлтөд туслах суурь материалыг бий болгох	6-18 насны 300 хүүхэд, 65 хүнээс авсан асуулга судалгааны дүнд нийслэлийн худалдааны захууд дээр хөдөлмөр эрхэлдэг хүүхдийг нөхөн сэргээх чиглэлээр төрийн ба төрийн бус байгууллагыг дэмжсэн хөтөлбөр хэрэгжүүлсэн.	Монгол улсын их сургуулийн Хүн ам зүйн сургалт судалгааны төв	Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр, Засгийн газар
Монгол улс дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба хууль эрхзүйн орчин (2002 он)	Эмэгтэйчүүдийн эрх, эрх чөлөөний эсрэг гарч байгаа хүчирхийлэл, тухайлбал; төр, нийгэм, эдийн засаг, соёлын хүрээнд эмэгтэйчүүдийн эсрэг сэтгэл санаа, бие мах бодь, бэлгийн зэрэг хүчирхийллийн илрэх хэлбэр, шалтгааныг тодруулах	Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хуулийг шинээр боловсруулах нэг үндэслэл болсон. Эмэгтэйчүүдийн эсрэг гарч байгаа бүх хэлбэрийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох, гэрч хохирогчийг	“Хүний эрх ба хөгжил төв”, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийг хэрэгжилтийг хянан үндэсний сүлжээний төв, НҮБ-ын эмэгтчүүдийн хөгжлийн сангийн “Итгэлийн сан”	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв

<p>Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл ба түүний эрүүл мэндийн үр дагавар (2004он)</p>	<p>Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийн тархалт, хэлбэрийг тогтоон түүнээс үүссэн эрүүл мэндийн үр дагаврын асуудалд олон нийт, шийдвэр гаргагчдын анхаарлыг төвлөрүүлэн, шийдвэрлэх арга замыг тодорхойлох Монголд өсвөр үеийнхний жирэмслэлтийн нөхцөл байдал болон үр дагаврыг тодорхойлох</p>	<p>хамгаалах зөвлөмж журмыг зохицуулах удирдамж гаргасан. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн үндэслэл болж байна.</p>	<p>Эрүүл мэндийн яам, Эмнэлгийн тусламжийг удирдах газар, НҮБ-ын Хүүхдийн сан</p>	<p>НҮБ-ын Хүүхдийн сангийн төлөө лөгчийн газар</p>
<p>“Өсвөр үеийнхний жирэмслэлт монголд” чанарын судалгаа (2004 он)</p>	<p>Монголд өсвөр үеийнхний жирэмслэлтийн нөхцөл байдал болон үр дагаврыг тодорхойлох</p>	<p>Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн 2005-2007 оны дунд хугацааны бодлогын хүрээнд өсвөр үеийнхний нөхөн үржихүйн боловсролыг асуудлаар тусгах зорилтын үндэслэл болно</p>	<p>Эрүүл мэндийн яам, Эмнэлгийн тусламжийг удирдах газар, НҮБ-ын Хүн амын сан</p>	<p>Монголын өсвөр үеийнхний аж байдлыг сайжруулах төсөл/НҮБ-ын агентлагуудын хамтран хэрэгжүүлсэн/</p>
<p>Хүнийг хил дамжуулан худалдах гэмт хэрэг-Монголд 2000 Эмэгтэйчүүд хүүхдийг худалдах гэмт хэргийн байдал (2002он)</p>	<p>Энэ төрлийн гэмт хэргийг судлах Энэ төрлийн гэмт хэргийн байдлыг судлах</p>		<p>“Хүний эрх хөгжил төв”</p>	<p>Хүний эрхийн үндэсний комисс</p>
<p>Хүүхдийг бэлгийн замаар ашиглах, хил дамжуулан худалдах байдалд хийсэн тайлан (2002он)</p>	<p>Энэ төрлийн гэмт хэргийн байдлыг судлах</p>		<p>ЕСРАТ</p>	<p>Монгол улсын Засгийн газар</p>

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР